

## СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 5 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ

2020.05.25

Баянцогт

Тус сумын Засаг даргын Тамгын газраас Монгол Улсын Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 2020 онд дэвшүүлсэн зорилтын хүрээнд 05 дугаар сард дараах ажил арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд:

### **Нэг.ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын ЗДТГ, болон Рашаант тосгон нь Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн ажиллаж байна. Мөн Улс орон даяар Ковид-19 халдварт өвчиг гарсантай холбоотойгоор 5 дугаар сард өндөржүүлсэн бэлэн байдалд шилжин ажилласан сар байлаа. Энэ сард ЗДТГ-нь дээд шатны байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу төрийн албан хаагчдад болон бусад төр, төсвийн байгууллагын албан хаагчдад тухай бүр нь хүргүүлэн үүрэг даалгавар өгч ажилласан.

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж Ковид-19 халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Сумын төвийн ЗДТГ-ын дэргэдэх шуурхай штаб, Рашаант тосгоны Шуурхай штабуудад иргэдийг цаг үеийн мэдээллээр хангаж, сонор сэрэмжийг дээшлүүлэх үүднээс шуурхай штабын Хариуцлагатай жижүүрүүдийн хуваарийг шинэчлэн баталж, бусад байгууллагын хариуцлагатай жижүүрүүдийг удирдлага арга зүйгээр ханган, Мэргэжлийн хяналт болон Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг даалгаваруудыг хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Ковид-19 халдварт өвчний үед бэлтгэл бэлэн байдлыг хангах үүднээс сумын төв болон Рашаант тосгоны Шуурхай штабуудтай хамтран гэр хороолол болон, Орон сууц хорооллуудаар тухайн өдрийн хариуцлагатай жижүүрүүд чанга яригчаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээ болон Улсын онцгой комиссоос **“АМНЫ ХААЛТАА ЗҮҮЦГЭЭ”** аяныг өрнүүлэн иргэдэд амны хаалтаа зүүж хэвших талаар шаадлага тавин ажиллаж байна. Мөн бусад байгууллагуудын хариуцлагатай жижүүрүүд сумын шуурхай штабын Хариуцлагатай жижүүрт мэдээллийг тухай бүр тогтмол цагт мэдээ өгч байна.

Сумын хэмжээнд үйдл ажиллагаа явуулдаг Худалдаа үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудад Ковид-19 вирусын ариутгал халдваргүйтгэл, өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжлийн байгууллагаас ирсэн зөвөлгөө мэдээллийг хүргүүлэн цаг тухайд Зөвөлгөө мэдээллээр ханган ажилласан. Мөн хүэсний үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагуудад “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн 2.23.4 заагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хүргүүлэн биелэлтийг гарган Мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлсэн байна. Одоогоор зөрчил гаргасан аж ахуйн нэгж байгууллага бүртгэгдээгүй байна.

Сэлэнгэ аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2020.05.11-ны өдрийн 46 тоот, Орхонтуул сумын Иргэдийн төлөөлөгчдийн

хурлын тэргүүлэгчдийн 2020.05.15 1/27 тоот “Төрийн албан хаагчдын сахилага хариуцлагын сайжруулах тухай” албан тоотыг төрийн албан хаагчдад танилцуулан гарын үсгийг баталгаажуулан, зөрчил гаргалгүй ажиллахыг Захирагч үүрэг болгосон бөгөөд албан хаагчид хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

### **Хууль эрх зүйн сургалт сурталчилгааны талаар**

Өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж олон нийтийг хамарсан үйл ажиллагаа явуулхыг хязгаарласантай холбоотойгоор албан хаагчид цахимаар Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Зөрчил гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Газрын харилцаа, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн талаарх мэдээлэл, зэргийг Орхонтуул ЗДТГ, Орхонтуул сумын вэб хуудас, захирагчийн албаны цахим хуудсанд байршуулан сурталчилсан байна

**Тодорхойлолт:** Нийт 52 тодорхойлолт гаргасан байна. Үүнээс ам бүл-35, өвөлжөөний газар-2, бусад 5, тус тус гаргасан байна.

**Ирсэн бичиг:** 5 сард 58 бичиг ирсэнийг бүртгэж холбогдох албан тушаалтануудад хүргүүлж хариутай бичиг 26 байсныг цаг тухай бүрт нь файлаар явуулсан байна.

**Явсан бичиг:** 67 бичиг төлөвлөн албан байгууллагуудад хүргүүлсэн байна. 2 бичиг нь мэдэгдэл хүргүүлэх, бусад бичиг нь хүсэлт санал хүргүүлэх тухай бичиг байна.

Мөн цаг үетэй холбогдуулан засаг даргын засаг захирамж гарган иргэдийн эрүүл мэндийг хамгааллыг сайжруулах зорилгоор сумын хэмжээнд архи согтууруулах ундаагаар үйлчлэх газруудад цагийн хязгаар тогтоож, сумын төвөөс гарах, орох хөдөлгөөнийг түр хугацаагаар хязгаарлалт хийн захирамжийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Зорчих хөдөлгөөнийг түр хаасантай холбогдуулан сумын төвөөс орох гарах хөдөлгөөнийг хязгаарлан сумын төвд 2 цагдаагийн пост , рашаант тосгонд 1 постыг тус тус ажлуулж хяналт тавьж ажилласан.

**Улсын бүртгэл:** Энэ сард шинээр төрөлт-8 Нас барсан-2, гэрлэлт-1 Шилжиж ирсэн-0, иргэний үнэмлэх олголт-4, биеийн давхцахгүй өгөгдөл-10, лавлагаа 16, овог нэр өөрчлөлт 1, нийт 28 иргэнийг бүртгэж онлайн санд шивэгдсэн байна. Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж “Шинэ төрсөн хүүхэд, эхэд хүндэтгэл үүүлэх журам”-ыг тогтмолжуулан шинэ төрсөн 5 хүүхэд хүндэтгэл үзүүлээ. 2020 оны 4-р сард 16 нас хүрсэн 4 иргэн, 25,45 насны хугацаа сунгалт 6 иргэн, хаяж гээгдүүлэн дахинаар-3 иргэнийг бүртгэн анхны болон солих мэдээллийг цаасан хэлбэрээр архивын санд нэгтгэн иргэний хувийн мэдээллийг DVD-нд хуулбарлан УБХ-ийн Улсын бүртгэгчид хүлээлгэн өгч ажиллалаа.

**Нийгмийн даатгал:** Нийгмийн даатгалын төвлөрсөн санд ажил олгогч даатгуулагчдаас 5 сарын 22-ны байдлаар 1768.6 мян төгрөгний шимтгэлийн орлого, эрүүл мэндийн даатгалын санд 9 даатгуулагчаас 258.3 мян төгрөгний орлого төвлөрүүлсэн байна. Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд 3 иргэдийг шинээр хамруулан 5 иргэний гэрээг шинэчлэн байгуулсан ба шинээр

малчин -2хамруулсан. Шимтгэлийн орлого сайн дурын даатгалд 7 иргэний 518.6 төгрөг, эрүүл мэндийн орлого 5 малчин, ажилгүй 4 иргэн эрүүл мэндийн даатгалаа төлсөн байна.

Тэтгэвэр тэтгэмжийг хугацаанд нь тавьж олгосон бөгөөд өндөр насны тэтгэвэрт - 190 иргэн, тахир дутуугийн тэтгэвэрт – 62 иргэн, тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 11 иргэнд харилцагч банкуудаар тус тус тавьж олголоо.

2020 онд хэрэгжиж байгаа нөхөн даатгалын материал 2 иргэний материалыг хянуулахаар хэлтэст хүргүүлсэн.

Тэтгэвэр шинээр тогтоолгох хүсэлт гаргасан 4 иргэний / өндөр настан-2, тахир дутуу-1 / тэтгэвэр хянагдаж, 1 иргэний өндөр настны тэтгэвэр хянагдан ирсэн. 1 иргэний тэтгэвэрийн жил нэмүүлэх хүсэлтийг хэлтэст хүргүүлэн хянуулан ирсэн.

Тахир дутуугийн тэтгэвэр авагч 4 иргэний хөдөлмөрийн чадвар түр алдалтын актыг хүлээн авч суналт хийлээ.

Энэ сард хариутай бичиг 1 ирсэнийг хугацаанд нь хэлтэст хүргүүлсэн. Зогсоогдсон хувийн хэргийг архивт хүлээлгэн өгөх ажлын дагуу 14 хайрцаг тахир дутуу тэжээгч алдсаны хувийн хэргийг янзалаж байна. Одоогоор ундар настаны хувийн хэрэг бүгд архивт очсон.

**Газар зохион байгуулалт:** 25 иргэний хаяг оруулж кадастрын зураг гаргаж үл хөдлөхөд бүртгүүлж ажиллалаа. 7 иргэн 5 аж ахуй нэгжийн өргөдөл гомдол хүсэлтийг хүлээн авч гомдол хүсэлтийн дагуу асуудлыг шийдвэрлэн мэдээллийн санд шинэ нэгж талбар оруулж шинэ хаяг өгч ажилласан. 2 иргэнд шинээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газраас өмчлүүлж ажилласан.

**Халамж:** Энэ оны 05- р сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн Халамжийн тэтгэвэрийг 38 иргэнд 20093,6 мян/төгрөг , Байнгын асаргаа шаардлагатай 19 ахмад настанд 4779,0 мян/ төгрөг , Байнгын асаргаа шаардлагатай иргэн 6 хүнд 1420,9 мян / төгрөг , Байнгын асаргаа шаардлагатай хүүхдийг асрагч 1 иргэнд 340,3 мян / төгрөг , Байнгын асаргаа шаардлагатай 1 хүүхдэд 519,7 мян /төгрөг , Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 25 иргэнд 1467,0 мян / төгрөг олголоо.

Жирэмсний тэтгэмжид 11 эхийг шинээр хамруулж нийт 17 эхэд 1251,2 мян/ төгрөг олгосон байна. Цалинтай ээжийн тэтгэмжид 80 жэхэд 11187,0 мянган төгрөг, өрх толгойлсон 4 эхэд улирлын тэтгэмж 1680,0 мянган төгрөг, баянцогт 2-р иргэн П.Цагаанд өвдөгний үе хийлгэсэн 5,0 сая төгрөг, ахмадын суилалд сувилуулсан 1 ахмөад настан хөнгөлөлт 192,5 төгрөгийг тус тус олгосон байна. Алдар цолтой 3 ахмад настанд тусламж 1500,0 мян / төгрөг олголоо . Байнгын асаргаа шаардлагатай ахмад настныг асрах тэтгэмжийн сунгалтыг 6 иргэнд хийж , шинээр тэтгэмжид 1 ахмад настанг орууллаа. Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах тэтгэмжийн сунгалтыг 3 иргэнд хийж , шинээр тэтгэмжид 2 иргэнийг хамрууллаа. Он гарсаар Цалинтай ээжийн тэтгэмжид 9 эх , Жирэмсэн эхийн тэтгэмжид 11 эх , Насны хишгийн тэтгэмжид 4 иргэнийг шинээр хамруулж , Шилжиж ирсэн Алдарт эхийн одонтой 1 эхэд хувийн хэрэг нээн явуулж , тэтгэмжийг олгохоор болоод байна .

Сэлэнгэ аймгийн ХХҮГ-т Алдарт эхийн 1,2-р одонтой нийт 177 эхийн захиалгыг хийж явуулан тэтгэмжийг 2-р сард 22300,0төгрөгний тэтгэмж олгосон. Мөн насны хишиг авагч 61 иргэний тэтгэмжийг бүрэн олгож дуусгасан байна.

2020 оны 5 -р сарын байдлаар Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдаагүй байсан 4 өрхийг шинээр судалгаанд хамруулж , амьжиргааны түвшинг нь тогтоолгож , хүүхдийн мөнгөнд хамруулж байна. Шинээр төрсөн 10 хүүхдийн бүртгэл хийж , материалыг аймагт явуулж , өрхийн судалгаанд хамруулж , хүүхдийн мөнгийг олгууллаа.Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 5 өрхийн 37 иргэнд 1208,0 мянган төгрөгний хүнсний 10 нэр төрлийн бүтээгдхүүнийг 5-р сард олгосон байна.

Халамжийн сангаас гарах бүх төрлийн судалгааг нэг бүрчлэн гаргалаа.

### **Хоёр.НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд ажил хайгчаар бүртгүүлсэн 3 иргэнийг LMIS программд бүртгэн баталгаажуулж ажил хайгч иргэнээр бүртгүүлсэн 1 иргэнд тодорхойлолт гаргаж өгсөн. Энэ сард ямар нэгэн аж ахуй нэг байгууллагад зуучлагдан орсон иргэн байхгүй байна. Хөдөлмөр эрхлэлтийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах иргэдийн саналыг авч аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газарт хүргүүлэн ажиллав.

Шинэ төрлийн Коронавирусын болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжүүдийг иргэд, төр төсвийн байгууллагууд, аж ахуй нэгжүүдэд цаг алдалгүй цахим болон цаасан хэлбэрээр тасралтгүй хүргэн ариутгал халдваргүйжүүлтийг тогтмол хийн ажиллаж байна. Мөн дээд шатны байгууллагаас хэрэгжүүлж буй “Амны хаалтаа зүүцгээе” аянд нэгдсэн. Дээд шатны байгууллагаас ирсэн мэдээ судалгааг цаг тухай бүрд нь хүргүүлэн ажиллалаа.

### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

1. Нийт 752 үзлэг хийгдэснээс урьдчилан сэргийлэх үзлэг-85, амбулаторийн үзлэг-327, идэвхтэй хяналтаар-75, гэрийн эргэлт-148, дуудлага-92 үүнээс алсын дуудлага- 7,гэрийн дуудлага 18 байна.
2. Жирэмсний хяналтанд 35 эх хянагдаж байна.
3. Артерийн гипертензия, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 75 хүнийг хамруулсан.
4. Хэвтрийн болон байнгын асаргаанд байдаг хүнд гэрээр тусламж үйлчилгээ үзүүлсэн.
5. ЭМД-д хамрагдсан 16 хүнд өдрөөр өвчний түүх нээж эмчилсэн.
6. 39 хүн хэвтэн эмчлүүлж, 318 ор хоног ашигласан.
7. 0-2 насны 59 хүүхдийг дархлаажуулсан.
8. ЭМ-ийн даатгалаар хөнгөлттэй эмээр 119 хүнд 1000010 төгрөгний эмээр үйлчилсэн.

9. ЭМС-ын 2019 оны А/537 тоот тушаалын 7-р хавсралтанд зааснаар нэг удаагийн хамгаалах өмсгөлийг 7 хоногийн 3 дах өдөр бүр өмсөж тайлах дарааллаар дадлага хийлгэн ажиллаж байна.
10. Хуваарь гарган 27 албан байгууллагаар 7 хоног тутам халдваргүйтгэлийг тогтмол хийж хэвшсэн.
11. “COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааг давхардсан тоогоор 28 байгууллага, 5450 хүнд хийж, худалдаа үйлчилгээ эрхлэн явуулдаг ААН, банкуудаар 3 удаа явж уг өвчний сэрэмжлүүлэг болон санамж хуудас гарын авлага тараасан.
12. Өдөр тутмын мэдээг тосгон сумын шуурхай штаб, аймгийн ЭМГ-ын шуурхай штабт цаг тухайд нь мэдээлж хэвшсэн.

### Боловсролын чиглэлээр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Шуурхай зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах тухай” 2020 оны А/43 тушаалын дагуу сургуулийг 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түр зогсоох шийдвэр гарсан. Сэлэнгэ аймгийн боловсрол соёл урлагийн газрын 2020.01.28ны 56тоот албан даалгаврын дагуу 2020.02.03 наас үндэсний хэмжээнд зохион байгуулагдаж байгаа теле хичээлүүдийг багш нар өөрсдөө үзэж, суралцагчдад цахим сүлжээ гар утас ашиглан чиглүүлэн заавар зөвлөгөө өгч дасгал даалгавар ажлуулж эхлээд 3 сар гаран хугацаа өнгөрсөн байна.

- Сурагчид сургалтын хөтөлбөрийн хүрээнд телевизээр тогтсон хуваарийн дагуу хичээлээ судалж байна.
- Алслагдсан болон зурагт үзэх боломжгүй байгаа сурагчдад нэмэлт даалгавар өгч байна.
- Сэлэнгэ аймаг БСУГ-ийн чиглэлийн хүрээнд баасан гариг бүр нөхцөл байдлын мэдээг явуулж байна. Нийт 314 суралцагчдаас теле хичээл үзэж байгаа суралцагчийн тоог бүлгээр харьцуулбал

№	Боловсрол	Теле хичээл үзэж байгаа сурагчийн тоо	Чадахгүй байгаа сурагчийн тоо	Хамрагдах ёстой сурагчийн тоо
1	Бага	150	14	164
2	Дунд	87	16	103
3	Бүрэн дунд	40	7	47

04.23 ны өдөр БСУГ-аас цахим хурал зохион байгуулсан. Мөн 05.05 өдөр ЭЕШ бэлдэж байгаа багш нартай БСУГ цахим хурал зохион байгуулсан. Үүнд суралцагчийг хэрхэн бэлтгэж байгаа хүүхдүүдтэйгээ ямар байдлаар харилцаа холбоо тогтоон ажиллаж байгаа талаар ярилцаж заавар зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан.

Коронавирус буюу covid 19 халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд цахимаар зохион байгуулагдаж байгаа үйл ажиллагаанд оролцож хариуцлагатай жижүүрийг тогтмол хийж байна.

- “Хариуцлагатай жижүүр” нь худалдааны цэг, олон нийтийн үйлчилгээний газар, дөхөм, гурт, хонхор хороолол, орон сууц, хүүхдийн тоглоомын

талбай зэрэг олноор бөөгнөрөл үүсгэдэг газруудаар 12:00- 20:30 цаг хүртэл тогтмол эргүүл хийж байна.

- Энэхүү ажлын хүрээнд Рашаант ЕБС нь “УРИАЛГА” гарган ажилласан. Хөл хорио тогтоон өндөржүүлсэн бэлэн байдалд шилжсэнтэй холбоотой бүртгэлийн хуудсыг эргүүлүүд өдөр бүр тогтмол бөглөж байна.
- “Бахархалт бичиг үсэг минь” нийтийг хамарсан цахим уралдааныг Рашаант тосгоны нийт иргэдийн дунд зохион байгуулсан. Рашаант тосгоны 51 хүн оролцов. Үндэсний бичиг, кирилл бичгийн төрлөөр тус тус 3 байр шалгаруулсан. Шалгарсан 6 иргэний 5 нь 5-12 дугаар ангийн суралцагчид, 1 нь "Ган зам" сүлжээ дэлгүүрийн худалдааны зөвлөгч байв. Шагналыг сургуулийн ерөнхий менежер Н.Бүрэнцогт гардуулсан. Оролцсон бүх иргэнд талархлын бичиг цахимаар хүргүүлсэн.
- "Номын ертөнцөөр аялсан өдрүүд" уралдаанд Монгол хэл уран зохиолын багш Г.Нарантуяа дэд байр, 6 дугаар ангийн сурагч Б.Мөнхзул гутгаар байранд тус тус шалгарсан.
- Сургуулийн фейсбүүк хуудсыг ашиглан зөвлөмж, мэдээг тогтмол хүргэж байна. Хүүхдэдээ анхаарал халамж хэрхэн тавих вэ? Хүүхдүүд гэртээ цагийг үр дүнтэй, хөгжилтэй өнгөрүүлэх 5 алхам зэрэг хорио цээрийн үед гэр бүлтэйгээ хамт байхдаа эерэг, зөв өнгөрүүлэх талаарх зөвлөмж, мэдээг хүргүүлж ажиллалаа.

Тогтмол ариутгал цэвэрлэгээ хийж байна. Цаг тухай бүрийн мэдээ тайланг шаардлагатай албан тушаалтанд хүргүүлэн ажиллалаа. Сургуулийн гадаах модыг усалж, цэцэгжүүлэлт суулгасан. Сургуулийн урд талын засмал замд хурд сааруулагч хийж гүйцэтгэсэн.

БСШУС-ын сайдын А220 тоот тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн суралцагчдад сургуулийн орчинд элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх давтлагыг 2020 оны 5 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаатай зохион байгуулж ажиллаж байна. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх, давтлага зохион байгуулахад мөрдөх зааврыг сахин биелүүлж байна.

1. ЕБС-ийн 12 дугаар анги нь нийт 29 суралцагчидтай бөгөөд бүгд ЭЕШ-д бэлдэж байна. Суралцагчийн биеийн халууныг давтлага эхлэхээс 10минутын өмнө үзэж, амны хаалтыг тогтмол зүүлгэж, гарыг нь ариутгуулж байна.
2. Сургалтын үйл ажиллагааг зохион байгуулахын өмнө нэг ширээнд нэг суралцагч суух, ширээ хоорондын зай 1-1.5 метр байхаар ширээ сандлыг байрлуулна.Тогтоосон дэгийг мөрдөн хуваарийн дагуу ажиллаж байна.
3. Нэг танхимд 10-аас илүүгүй сурагч байхаар тооцоолон хоёр танхим бэлтгэн, багшийн хичээлийн хуваарийг төлөвлөсөн. Сургалт 40 минутаар хичээллэж, 20 минут ариутгал халваргүйтгэлийг хийж дараагийн давтлага хичээллэх бэлтгэл ажлыг хангаж байна.
4. Сургуулийн орох цэг дээр нэгдсэн нэг гар ариутгагч байгаагаас гадна хүүхэд бүр өөрсдийн гар ариутгагчтай танхимд хичээллэж байна.
5. Анги танхимд 40 минут тутамд 10-15 минутын агаар сэлгэлт хийж, ээлж хооронд анги танхимд цэвэрлэгээг тогтмол хийж байна.

6. Бал үзэг, цаас, ном дэвтэр, утас таблет, notebook, флаш гэх мэт аливаа хэрэглэгдэхүүнийг бусдад дамжуулж хэрэглэхгүй байх тал дээр анги удирдсан багш, сургуулийн эмч мэдээлэл өгч хамтран ажиллаж байна. Суралцагчид давтлагад ирэх бэлтгэл ажлыг хангасан байх шаардлагатайг эцэг эх, асран хамгаалагчдад анхааруулж мэдээлэл зөвлөгөөг хүргүүлж ажилласан
7. Сандал ширээ, самбар, номын ширээ зэрэг хатуу гадаргууг ахуйн хэрэглээний бодисоор цэвэрлэж байна. Дараагийн давтлага эхлээс өмнө 20 минутыг ариутгал цэвэрлэгээ хийхэд зарцуулан ажиллав.
8. Анги танхимд гадуур хувцас байлгадаггүй бөгөөд суралцагчид өөрсдийн шкафанд гадуур хувцас, шаардлагатай эд зүйлсээ хийж бэлтгэсэн 2 танхимд хуваагдан давтлаганд суудаг.
9. Суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдэдээ уух зүйл бэлтгэн өгч, өглөө өдрийн хоолыг гэрт нь тогтмол уулгаж дархлааг нь дэмжиж байхыг анхааруулсан учраас сурагчид анги танхимд хоол, хүнсний зүйлийг хэрэглэхгүй байна. Суралцагчид зөвхөн өөрсдийн усны сав, аягыг авчран төвийн шугамд холбогдсон шүүгчээс халуун бүлээн усыг авч давтлага хийж байх хугацаандаа хэрэглэж байна.
10. Урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг сургуулийн ханын самбар болон анги танхимын эрүүл мэндийн буланд байршуулсан. Мөн суралцагчийн баримтлах дэгийн ширээн дээр наасан.

Сайдын тушаалын хэрэгжилтийг хэрхэн биелүүлж ажиллаж байгаа талаар бодит байдалтай танилцахаар БСУГ- аас 05.12 өдөр хүмүүс ирж ажилласан.

“Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс танхимын сургалт эхэлсэнтэй холбогдуулан covid19 урьдчилан сэргийлэх үүднээс гар ариутгагч, амны хаалт, бээлий, витамин зэрэг гарын бэлгийг суралцагчид болон багш ажилчдад өгсөн.

### **Гурав. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Сумын Хүнсний хангамжийн бодит нөөцийн мэдээг дээд газраас ирсэн маягтын дагуу долоо хоног бүрийн пүрэв гаригт хүнсний 7 дэлгүүрээс авч нэгтгэн гаргаж, холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа. Мөн төмс, хүнсний ногооны нөөцийн хангамж, түүхий эдийн агуулахын мэдээг гарган хүргүүлсэн байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ийг шинэчлэн баталсны дагуу хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах ажлыг 04-р сарын 20-ны өдрөөс 05-р сарын 19-ний өдөр хүртэл хугацаанд зохион байгуулж байна.

Засгийн газраас малчдад Ноолуурын урамшуулал олгохтой холбогдуулан 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А-дансандаа ямаа тоолуулсан малчдын дансны дугаарыг авч аймгийн ХХАА-н газарт хүргүүлсэн. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах сумын Засаг даргын Захирамжийн дагуу сумын хэмжээнд шөвөг яр, ДХХ өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгыг 100%, боом өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга 82%-тай хийгдээд байна.

## **Дөрөв.ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

2020 оны 05 сарын 01-нээс 05 сарын 25 -ныг хүртлэх хугацаанд тус сумын Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллага болох сумын, ЗДТГ, ИТХурал, 1-р сургууль, Соёлын төв, 1-р цэцэрлэг, Рашаант ЭМТөв, зэрэг төсөвт байгууллагуудын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 77,824,8 мянган төгрөгийн төлбөр тооцоог, анхан шатны бичиг баримтыг үндэслэн 47 ширхэг төлбөрийн хүсэлтээр 60 удаагийн хандалтаар ЗГУМСистемд ажил гүйлгээг шивж баталгаажуулсан байна.

Төсөвт байгууллагууд албан бичгийн дагуу ЗГУМСистемд хийх ажил гүйлгээг эрэмбэлж, анхан шатны баримтын бүрдэл бүхий баримтаар гүйлгээ хийгдсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажилласанаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн мэдээлэгдсэн.

Аймгийн статистикийн хэлтэст графикийн дагуу ХАА-1,2,3,6 мэдээ, АҮ-мэдээнүүдийг аймгийн Статистикийн хэлтэст илгээгдэж баталгаажсан ба, 2020 оны хагас жилийн мал тооллого эхлэн явагдаж байна.

### **МЭДЭЭ БИЧСЭН:**

ТЭ,ХЭЗ, ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.БАТЧИМЭГ

### **ТАНИЛЦАЖ,ХЯНАСАН:**

ЗДТГ-Н ДАРГА

Ш.ӨНӨРБАЯР